



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/71

Даланзадгад

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2019 оны "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" батлах тухай А/406 дугаар тушаал, 2020 оны А/408 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд "Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл" аяныг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, аяны удирдамжийн дагуу шалгаруулалт хийх ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. "Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл" аяныг удирдамжийн дагуу 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, удирдамжид заасны дагуу уриа, зорилгоо тодорхойлж, эмч ажилтнуудад зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг төр, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын дарга эрхлэгч наарт үүрэг болгосугай.
3. "Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл" аяныг мэргэжил арга зүйгээр хангаж, тушаалын хэрэгжилтэд явцын хяналт хийж, аяныг шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулах тайлагнах, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлах Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга /М.Цэндсүрэн/-д үүрэг болгосугай.



C:\ Desktop\2020 on TUSHAAL

461200179

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
09 дүгээр сарын 01-ний өдрийн А/71  
дүгээр тушаалтын нэгдүгээр хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД “ЭЕРЭГ  
ХАНДЛАГА-ЭМЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛ” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл:**

2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/408 дугаар тушаал, Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг сайжруулах тухай 1а/ 3331 албан бичгийг үндэслэн эмнэлгийн тусlamж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх, үйлчлүүлэгчийг угтах, эрүүл мэндийн зөвлөгөө өгөхөд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй харилцаа, эерэг хандлага, харилцааны соёл, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахад чиглэнэ.

**Хоёр. Зорилго:**

Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны ёс зүйг дээдэлсэн баг, хамт олныг төлөвшүүлэх, үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилчдын хоорондын эелдэг харилцаа хандлага, байгууллагын соёлыг сайжруулах оршино.

**Гурав. Хамрах хүрээ:**

Улсын болон хувийн чанартай эрүүл мэндийн бүх шатны байгууллага, тасаг нэгж хамрагдана.


**Дөрөв. Аяны үргэлжлэх хугацаа:**

1-р шат: 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл

2-р шат: 2021 онд тусгай удирдамжаар хэрэгжүүлнэ.

**Тав. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулагдах ажлын чиглэл:**


- “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяныг байгууллага хамт олонд чиглэсэн, үйлчлүүлэгч /иргэдэд/ гэсэн 2 чиглэлээр зохион байгуулна.
- Эрүүл мэндийн байгууллагын дарга нар сум, өрх, нэгжийн хүрээнд 3 сарын хугацаанд үр дүнтэй, хэрэгжих боломжтой, хэмжигдэхүйц үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулна.
- Байгууллага, хамт олны хэмжээнд аяны талаар танилцуулж, уриа, зорилгоо тодорхойлж, ажлын хэсэг байгуулах, ажилтны зөв харилцаа, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг дотооддоо боловсруулж, батлуулна. Хөтөлбөрийн батлагдсан төлөвлөгөөг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр ЭМГ-ын ажлын хэсэгт файлаар ирүүлнэ. Үр дүнг үнэлэх үнэлгээний хэсэг болно.



4. Байгууллага, нэгж дахь аяныг зохион байгуулах ажлын хэсэг нь үнэлгээний хуудсаар 7 хоног бүр ажилтныг шударга зарчмаар үнэлнэ.
5. Аяны хүрээнд ажилчдыг ажилдаа хандах зөв хандлагатай, чин сэтгэл гаргаж, ажлаа хариуцлагатай хийдэг, цаг баримталдаг, ёс зүйг дээдэлсэн харилцааг дэмжсэн байхаар зохион байгуулахыг эрмэлзэнэ.
6. Аяны хугацаанд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн чиглэлээр дотоодын сургалтыг тасралтгүй хийх, мэдлэг олгох олон талт арга хэмжээг зохион байгуулах, иргэдэд зориулсан эерэг сурталчилгааг нөлөөллийг төрөл бүрийн арга ашиглан явуулна.
7. Иргэд, үйлчлүүлэгчдээс ирэх санал, талархал, гомдол, чирэгдэлтэй үйлчилгээг хүлээн авдаг нээлттэй утас бий болгох, улмаар тусlamж үйлчилгээг сайжруулахад чиглэсэн эргэх холбоотой байгууллагын соёлыг бий болгох ажлыг төлөвлөн, хэрэгжүүлнэ. Үр дүнг тоон ба чанарын үзүүлэлтээр дүгнэнэ.
8. Аяны хүрээнд “Аймгийн эрүүл мэндийн салбар”-ын хэмжээнд жишиг харилцаа хандлагатай, ёс суртахуунтай хамт олныг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх, урамшуулах, дэмжих, сурталчлахад ач холбогдол өгч ажлыг төлөвлөн зохион байгуулна.

**Зургаа. Тайлاغнах, урамшуулах:**

9. Аяны хүрээнд шударга, тэгш, зарчимч байдлаар дотооддоо дүгнэж, шаардлага хангахуйц тайланг ЭМГ-ын ажлын хэсэгт хугацаанд нь ирүүлнэ.
10. З сарын аяны ажлын бичмэл тайланг зургаар баталгаажуулан файлаар /бичлэг хавсаргаж болно/ 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ЭМГ-ын ажлын хэсэгт ирүүлнэ. Ажлын хэсэг шалгуур үзүүлэлтээр үнэлэн шалгаруулна.
11. Удирдамжийн дагуу шалгуур үзүүлэлтээр байр эзлүүлж, тэргүүлсэн байгууллага, хамт олон, ажилтныг шалгаруулж, аяны шилдэг ажлын тайланг дээд шатны байгууллагад илгээх, урамшуулах, сурталчлах, ажлыг зохион байгуулна.



Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
09 дүгээр сарын 01-ний өдрийн А/71  
дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

**“ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭМЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛ” “АЯНЫ ХҮРЭЭНД  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч – ЭМГ-ын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн  
дарга М.Цэндсүрэн

Ажлын хэсгийн нарийн бичиг - ЭТЧАБ-ын мэргэжилтэн С.Туяацэцэг

Гишүүд:

- ЭМГ-ын ЭТҮХ-ийн дарга Ж.Отгонбайгал
- ЭМГ-ын ХШҮМХ-ийн дарга Б.Мидэрсүрэн
- ЭМГ-ын УТСХ-ийн мэргэжилтэн Ж.Наранжаргал
- ЭМГ-ын ЭТҮХ-ийн мэргэжилтэн Г.Амартувшин
- ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны  
дарга Д.Дэлгэрсайхан
- Өрхийн холбооны тэргүүн Л.Лхагвасүрэн
- Хувийн хэвшлийн холбооны тэргүүн Р.Тунгалаг